



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 4/62

Амардалай

Зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66,1 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, ^{арь багасан} Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний 86 тоот тушаал, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 31 дугаар тогтоолын хавсралт 2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мал эрүүлжүүлэх дархлаажуулахад зориулагдсан вакцин хадгалах хөргүүрт 14,600,000 төгрөгийн зардлыг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсугай.

2. Нийт 14,600,000 (Арван дөрвөн сая зургаан зуун мянган) төгрөгийг Сумын Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалтын дагуу гаргаж зарцуулахыг нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

М.БАЯРСҮХ